

**ЗАН БАЙДЛЫН ОНЦЛОГИЙГ ИЛЭРХИЙЛСЭН
ШУУД БУС НЭРЛЭЛТ БҮХИЙ ҮҮСМЭЛ ҮЙЛ ҮГСИЙН ТУХАЙД**

Г.Даваажаргал*

Хүний шинээр бүтээн бий болгосон, бас шинээр танин мэдсэн болгоныг нэрийдэх хэрэгцээ шаардлага урган гардаг. Тэрхүү шинэ ухагдахууныг тэмдэглэхийн тулд цоо шинээр үг бүтээх нь бараг үгүй бөгөөд уул хэлний үгийн санг ашигладаг байна. Өөрөөр хэлбэл, уугуул байсан үгийн сангийн нэгжийн ухагдахууны багтаамж, агуулгыг өргөтгөн ашиглана.

Хэлэнд шинэ утга үүсэх нэг гол арга нь үг бүтэх ёс юм. Тодруулбал, шинэ үүсмэлийн үзэгдэл бүр шинэ утгыг тэмдэглэж, утгын шинэ үзэгдэл нь хэлэнд ямар нэг юмын тухай илэрхийлж, мөн үг бүтэх ёсны баримттай холбоотой байдаг. Орчин цагийн монгол хэлэнд үгийн язгуур, үндсэнд дагавар залгаж үг бүтэх залгаврын арга (нийлэг), хоёр өөр язгуур бүхий үгс хоршиж, хавсарч бүтэх үг нийлэх арга (задлаг) гэсэн хоёр үндсэн арга байна. Бид энэхүү өгүүлэлдээ дагавар¹ын аргаар үүсч шууд бус нэрлэлт болсон үйл үгсэд хүний зан байдлын зарим онцлог хэрхэн туссан байгааг тодруулахаар зорилоо.

Шинэ нэрлэлт нь үг бүтэх ёсны баримтын явцад шинэ утгыг хэлбэржүүлэх ба гагцхүү тэр нь шинэ гэдгийг тогтоох нь тун чухал бөгөөд хэлний тэмдгийн “анхны” илэрхийллийг “*хоёрдугаар*” нь түшиж гарч ирэх ажээ. Үүсмэл бус үг нь үүсмэл үг бүтээх суурь болдог учраас түүний утгыг тодорхойлох үндэс болно хэмээн бид үзэж байна. Жишээ нь: *бөөрөнхийлөх* гэхэд бөмбөрцөг, бөмбөгөр, бөмбөг мэт хэлбэртэй юм² гэх үгийн язгуурын үндсэн утгаас буюу бөөрөнхий хэлбэртэй юм тэгш гадаргуу дээр тогтдоггүй, өнхрөөд байдаг шинжээс улбаалан хэн нэгэн хүний тогтворгүй, шийдвэргүй, бөөрөнхий үзэл гаргах гэсэн утга бүхий шууд бус нэрлэлт үүссэн бол

*“Гурван-Эрдэнэ” БДС-ийн багш, МУИС-ийн докторант.

¹О.С.Ахманова “*Үгийн бүтцэд язгуурын дараа байрлах залгавар бүтээврийг дагавар гэнэ.*”

Ш.Лувсанвандан “*Монгол хэлний үгийн дагавар нь язгуурынхаа дараа шууд ба шууд бус залгасан байдаг.*”

А.Лувсандэндэв “*Үг бүтээх дагавар хэмээгч нь язгуурын дараа орж бодос, шинж тэмдэг, үйлийн анги зэргийг илтгэх залгавар юм*”

П.Бямбасан “*Язгуурт шууд залгаж болох, хэлний юм үзэгдлийн дохио болж чадах залгавар бүтээврийг дагавар гэнэ*”

²Цэвэл Я.(1966)*Монгол хэлний товч тайлбар* толь.Улаанбаатар.,

нарийлах гэхэд нарийн гэсэн тэмдэг нэр язгуур нь бүдүүн, өргөн гэсэнтэй эсрэгцэлдсэн үндсэн утгатай ба эндээс, юманд болгоомжтой хянамгай хандах, хичээнгүйлэх, харамлах, гамнах³ гэх шууд бус нэрлэлт үүссэн нь жижиг нарийн амсартай савнаас/саванд аливаа зүйлийг маш бага хэмжээгээр гаргаж/оруулдаг үйлтэй адилтгасан ажээ. Түүнчлэн, цаг агаар гэнэт хувирч, тэнгэр муухайрахыг хүйсганах гэнэ. Энэхүү огцом өөрчлөлтийг илэрхийлсэн язгуурын утгаас адилтган үүссэн шууд бус нэрлэлт бүхий үг нь гэнэт царай нь хувирч уурлан, муухай ааш гаргах⁴ гэсэн утгаар хэрэглэгдэж байна.

Бидний жишээлэн буй, дагаврын аргаар бүтэж, дам нэрлэлт үүсгэх үйл үгс нь тухайн өгүүлбэрийн, цаашилбал уг ярианы үнэ цэнийг улам нэмэгдүүлэх шинжтэй байх бөгөөд аливаа яруу хэрэглүүр нь юмыг ерийн илэрхийлдэгээс “гажжуудуулж”, яаж ийгээд “өөрөөр” хэлсэн байдгаараа онцлог юм.

Хэлний тухайн илэрхийлэл яруу илэрхийлэх чадамжтай байна гэдэг бол хамгийн ерөнхийгөөр хэлбэл, харилцах хэрэгцээндээ зориулж хэлээ ашиглаж, хэрэглэж байгаа хэрэг гэж ойлгож болно⁵. Яруу илэрхийлэх зүй нь ямагт субъектив (хийсвэр), онцгой, бие хүний шинжтэй байх ба хамгийн түргэн зуурын байдлаас тогтвортой шинж рүү, агшин зуурын сэтгэл зовсон байдлаас тогтвортой шинж хүртэл хамаарах бөгөөд хүн, түүний ойр орчин төдийгүй, нийгмийн үе шат, ард түмэн, соёлд ч хүртэл хамааралтай⁶.

Түүнчлэн, үгийн утга дахь сэтгэл хөдлөлийн бүрэлдүүлбэр нь уран яруу илэрхийлэхтэй нягт холбоотой. Цаашлаад, сэтгэл хөдлөлийн үнэлэмжийг илэрхийлсэн үйл үгс нь найруулгын өнгө аясыг бүрдүүлэх боломжийг бий болгож улмаар яруу илэрхийлэх чадварын чухал эх булаг болно⁷.

Хэрэглэгдэхүүн болгон авч буй үйл үгсийн утгыг ажиглахад

1. Зан төлөвийн онцлогийг илэрхийлсэн
2. Авир араншинг илэрхийлсэн гэж хоёр ангилж болохоор байна.

Үүнийг тодруулбал:

1. Бусадтай харилцах харилцааны үед хүмүүсийн биеэ авч явах байдал онцгой мэдрэмтгий, уян хатан, эвсэг найрсаг, эелдэг зөөлөн, бүдүүлэг хэрцгий гэх мэт маш олон янз байдаг. Зан төлөв нь бие хүний харьцангуй тогтвортой шинж, онцлог төдийгүй, тухайн хүний ажил мэргэжил, хүрээлэн байгаа орчин, хүмүүст хандах хандлагыг илэрхийлэх⁸ ба, жалбиганах, навсаганах, нахиганах, нялцаганах гэсэн дүрслэх язгууртай үгсээр илрэх шууд бус нэрлэлт⁹ ийн утга нь

³ Мөн тэнд

⁴ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (2008) Улаанбаатар.,

⁵ Баянсан Ж. (2011) Бодгаль үнэлэмжийн хамсмал утгыг яруу илэрхийлэхүйн шалтгаалцал хэмээхүйн учир// МУИС-МХСС ЭШБ Том XXXII(340)16 х, Улаанбаатар.,

⁶ Телия В.Н. (1986) Коннотативный аспект семантики номинативных единиц. стр 5, Москва.,

⁷ Сандомирская И.И. Эмотивный компонент в значении глагола

⁸ Сэтгэл зүйд өөрөө суралцах нь. (2005) Удирдлагын академи 522 х., Улаанбаатар.,

⁹ Энэ тухай бид “Авиа дуурайх ба дүрслэх язгууртай үгсээр илрэх шууд бус нэрлэлтийн тухай”// Хэл зохиол судлал. (2010) Улаанбаатар. / өгүүлэлдээ тэмдэглэсэн болно.

“зусар байдал гарган ярих; хов зөөн хутган үймүүлдэг зан авир гаргах; бялдуучлан бөхөлзөх; нялуун зан гаргах” юм. Энэ нь, “жалбигар юмны үргэлжлэн хөдлөх; энд тэнд урагдан ноолорч, муудсан зүйл үргэлжлэн хөдлөх; уян зөөлөн юмны үргэлжлэн хөдлөх; нялцгар зүйл байн байн хөдлөх”¹⁰ гэсэн уг язгуурын утгаас санаа уламжилжээ. Тодруулбал, дээрх үгсийн язгуурын илэрхийлэх утга нь монгол хүний хэв ерийн гэж үздэг үйл хөдлөлөөс гажуу/муу үйлийг зааж, тэндээс үүссэн үгс нь сөрөг үнэлэмжийг илэрхийлдэг нь жишээ баримтаар нотлогдож байна. Улмаар, дам язгуур үүсгэх -*ga*⁴ залгаж үүссэн дээрх идэвхгүй язгуурт -*na*⁴ дагавар залгаж тухайн дүр байдал хоромхон тасалдаж давтагдах үйлийн аргыг заасан үйл үг үүсчээ. Тэгвэл эндээс, зарим дүрслэх утгатай язгуур, зарим дагавартай нийлж хүний зан байдлын шинжийг заасан шууд бус нэрлэлт бүхий үгс үүссэн гэж үзэж болох юм. Ингэхдээ хүний муу зан байдлыг илэрхийлсэн байгаа нь сонирхол татаж байна.

Түүнчлэн, *жороол*- гэдэг үгээр шууд бус нэрлэлт үүсэхдээ, үгийг эсрэг утгаар нь ойлгогдохоор хэрэглэж санаагаа илтгэн, уран дүрсэлж, яруу илтгэх хэрэглүүр болох егөөдл¹¹ийг ашиглажээ. Зүгээр морь бол баруун талын урд хөл, зүүн талын хойд хөлөө нэг зэрэг урагш гишгэж, дараа нь зүүн урд хөл, баруун талын хойд хөлийг зэрэг урагш гишгэдэг юм. Жороо морь бол баруун талын урд хойд хоёр хөлийг хамт өргөж урагш гишгээд дараа нь зүүн талын хойд урд хоёр хөлийг зэрэг өргөж урагш гишгэх¹² ба унахад зөөлөн байдаг. Тэгтэл дээрх үг, ярианд болон уран зохиолын найруулгад хэрэглэгдэхдээ морины жороо сайхан явдлыг илэрхийлсэнгүй, харин ч эсрэгээр утгыг өгөж “*бусдын өмнө сайн хүн болж харагдах гэж зусардан бялдуучлах*” гэсэн утгатай болжээ. Жороо морины явдал зөөлөн, унасан хүний ядрал бага, тааламжтай байдаг энэхүү шинжийг егөөдөн ашиглаж, бусдын ая талыг засах, өөрт ашигтай байлгахын тулд элдэв зөөлөн хуурмаг зан байдал гаргахыг *жороол*- гэдэг үгээр хэлэлцэж байна. “*Эр эм хоёрын хооронд илжиг битгий жороол*”, “*Хөгийн азарга жороо сурахгүй*” гэх зэрэг хэлцүүд ч мөн егөөдөн үүсчээ. Монголчууд морины жороо явдлыг сайхан гэж үздэг ч үүнийг илжигтэй юм уу, хүний үйл байдалтай холбон үүсгэсэн хэлц нь сөрөг үнэлэмжийг илэрхийлж байна.

Манжлах гэх үгийг *манж зан гаргах* гэж холбоо хэллэгээр хэлж болно. Үүний үүсгэл утгыг мөшгин хөөвөл 1661 онд Долоннуурын чуулганаар Халх Монголыг Манжийн харьяат гэж албан ёсоор зарласан байна. Тус чуулганаар Манжийн төрд гавьяа байгуулсан Халхын 5 хүнд чин ван, 6 хүнд жүн ван, 3 хүнд бэйл, 4 хүнд бэйс, 7 хүнд гүн, 6 хүнд тэргүүн зэрэг тайж олгож, 34 ноёныг хошууны засаг ноён болгож, тус 34 хошууг Түшээт ханы 16, Сэцэн ханы 11, Засагт ханы 7 ноёд хуваан захируулжээ¹³. Энэ мэтчилэн манжууд, элдэв янзын хөрөнгө мөнгө, гавьяа шагнал өгч ноёд ямбатнуудыг урвуулж, ард түмнийг

¹⁰ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (2008) Улаанбаатар.

¹¹ Гаадамба Ш. (1989) *Утга зохиолын онолын үндэс*. 134 х., Улаанбаатар.,

¹² Дамдинсүрэн Ц. (1969) *Түүвэр зохиол*. 322 х., Улаанбаатар.,

¹³ Монгол улсын түүх. дөтгөөр боть (2004) 120 х., Улаанбаатар.

дарлаж байсан тухай олон жишээ баримт түүхэн сурвалжуудад тэмдэглэгдсэн байна. Ингэж, өнгөн дээрээ тусыг үзүүлж байгаа мэт боловч далдуур цаагуур хорлох, мэхлэх зан байдал гаргахыг хэлэлцэхдээ *манжлах* гэдэг үгийг “*хуурамч зан гарган мэхлэх*” гэсэн шууд бус нэрлэлтийн утгатай болгожээ.

Энэ мэтчилэн жишээнээс харахад, хүний зүй зохист явдлаас гажууд зүйлийг илэрхийлэхдээ үүсмэл үйл үгсийг шууд бус нэрлэлтийн үүргээр ашигладаг ба ингэхдээ язгуурын болон дагаврын утгыг онцгой анхаардаг гэж болно. Учир нь үүсмэл үйл үг бүхэн шууд бус нэрлэлтийн утга хүлээдэггүй нь үүнтэй холбоотой.

2. Сэтгэл судлалын ном бүтээлд тэмдэглэснээр, авир араншин эн түрүүнд шинэ сэтгэгдэл төрөх, сэтгэл хөдлөх, цочиж сандрах, сэтгэлийн түгшүүр бий болох гэх зэрэг бие хүний зан үйлийг нөхцөлдүүлнэ. Шинэ сэтгэгдэл төрөх гэдэг нь хүмүүст янз бүрийн нөлөөлөл үзүүлэх, гадны хүчтэй цочроол үйлчлэх нөхцөлд ул мөр нь ойд хадгалагдан үлдэж, улмаар хариу үйлдэл үзүүлэх байдлаар илэрдэг¹⁴ ажээ. Хүний авир араншин түргэн зуурт ширүүн дориун болохыг илэрхийлсэн утгатай шууд бус нэрлэлт бүхий үүсмэл үйл үг монгол хэлэнд байгаагаас заримыг нь тайлбарлавал: *хуйхлах* гэхэд “*ширүүн догшин зан авир гаргах, ихэд загнах*” гэх утгыг илэрхийлнэ. Тэгвэл энэ үгийн анхдагч утга нь арьс, үс, өвс зэрэг зүйлийг галд шарах буюу улайтгасан төмрөөр хайрах зэргээр шатаах нь хурдан хугацаанд хийх үйлийг зааж байна. Анхдагчболон хоёрдогч нэрлэлтийг харьцуулан харвал хоёуланд нь “*түргэн*” гэсэн шинж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ шинжээр адилтгал үүсчээ.

Хаазлах гэвэл хаазаа дарж гишгэж машинд хурд хүч нэмэх гэх анхны утгаас, “*уурлах, ихэд аашлан загнах*” гэсэн шууд бус нэрлэлтийн утга үүсчээ. Энд, “*ямар нэгэн үйлдэл эрчимжих*” хэмээх шинжээрээ адилссан байна. Ер нь цухалдахуйн мэдрэмж маш хүчтэй, огцом хурдан өрнөж, бие махбодийн үйл ажиллагаа ба хариу үйлдэл, хөдөлгөөнийг эрс өөрчилдөг онцлогтойучраасмашины хөдөлгөөнийг огцом нэмэх үйлтэй адилтгажээ. Газ гэсэн орос үгийг монгол ярианы хэлэнд хааз гэж хэлж хэвшээд, улмаар энэ ормол үг шууд бус нэрлэлт бүхий болсон байна.

Дөвчигнөх, сүржигнэх хэмээх утга бүхий *бөөлөх* гэдэг үг нь дээр жишээлсэн үгстэй утгын орчлоороо ойролцоо бөгөөд энэ нь “*бөө хүн онгоноо оршуулах үйл хийх*”¹⁵ гэсэн анхны утгаас хэрэглээзүйн хувьд ондоо юм. Харин “*бөө хүн онгод нь орсон үедээ сүртэй байх*” шинжээр адилссан бололтой. Эндээс, тухайн үгийн шууд бус нэрлэлт нь ямар цаг үед үүссэн нь чухал гэж хэлж болох ба тус үгийн дам нэрлэлтийг бөөгийн шашны унал доройтлын үетэй холбон тайлбарлаж ч болох юм.

Жүжиглэх, илбэдэх гэсэн үгс нь уг язгуурын утгаас уламжлан “*хуурах, мэхлэх, аргалах*” гэсэн утгатай болсон нь тодорхой харагдаж байна. *Жүжиг* гэдгийг уран зохиолын онолын ном бүтээлд “*Гадаад ертөнцийн юмс үзэгдэл,*

¹⁴Сэтгэл зүйд өөрөө суралцах нь. Удирдлагын академи.(2005) 516 х., Улаанбаатар.,

¹⁵Цэвэл Я. (1966) Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.,

баатруудын хэрэг явдлыг харуулахын зэрэгцээ сэтгэл санааны байдлыг баатруудын үйлдэл, аяс хандлага, дохио зангаа зэргээр нээж бас уянгын зохиолын дүрслэлийн элементийг (санаа сэтгэл, хандлага, сэтгэлийн хөдлөл, догдлол, гутрал) өргөн ашигладаг өвөрмөц нарийн төрөл юм”¹⁶ гэж тодорхойлдог. Дэлхийн хэмжээний, жүжгийн алдарт зохиолч Уильям Шекспир¹⁷ “Энэ ертөнц бүхлээрээ тайз” гэж хэлсэн нь бий. Тэрээр, янз бүрийн хүмүүс болоод бүхэлдээ нийгэмд тохиолдож болох эгзэгтэй, ээдрээтэй, инээдэмтэй, эмгэнэлтэй бүхий л явдлуудыг харуулахдаа хүний мөн чанарыг дэлгэн нээж чадсан учир өөр цаг үе, өөр улс орон өөр үндэстэн, ондоо пашны хүмүүс жүжгий нь үзэж уншаад өөрийгөө болон өөрийнхөө амьдралыг олж таньдаг ажээ. Энэ бүхнээс эргэцүүлэхэд, монгол хэлэнд байгаа “хуурах” гэсэн утгатай *жүжиглэх* гэдэг үг нь “*жүжиг тоглоно гэдэг хуурмаг зүйл юм*” хэмээх утгаар хэрэглэгдээгүй байх гэж бид үзэж байна. Харин, жүжигт амьдралын элдэв зүйлийг дуурайдаг гэх нэг л утганцраас адилтган дээрх шууд бус нэрлэлт үүссэн бололтой. Илбэ гэдэг нь “хүний нүдийг хуурч сонин содон үзүүлбэр үзүүлэх” хэмээх үндсэн утгатай. Эндээс л “хуурах, мэхлэх” гэдэг шууд бус нэрлэлтийн утга адилтгаж үүсчээ.

Дээрх хоёр үг илэрхийлж буй утгын хувьд адил хэдий ч хэрэглэгдэх хам орчил нь өөр байна. Тодруулбал, “хуурах” гэсэн утга илэрхийлэхээрээ нэг хэдий ч, хэдийд, ямар үед хэрэглэгдэх нь өөр байж, найруулгын үүргээрээ ялгарах ажээ.

Дээрх үгсэд байгаа үг бүтээх -ла⁴, -д дагаврууд нь эдлэх, хэрэглэх, үйлдэх үйл бүтээнэ. Утга, хэрэглээгээр нь авч үзэхэд бидний, хоёрдугаар хэсэгт жишээлсэн үйл үгс авир араншингийн шинжийг буюу түргэн зуурын өөрчлөлтийг заасан байх юм.

Хүний зан төлөв нь мэдрэлийн тогтолцооны онцлогоос биш харин тухайн хүний соёлын түвшин, нийгмийн зан үйл, хүмүүжил, зан суртахуун, боловсролын байдлаас хамаардагаараа авир араншингаас ялгаатай. Гэхдээ хүний зан төлөвийн хөгжил хөдөлгөөний шинж онцлог нь авир араншинтай шууд холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл зан төлөв, араншинг илэрхийлж байгаа дээрх мэтийн үгсийн утгыг ажиглаж тухайн хүний онцлог болон түүнд бусад хүн хандах хандлагыг тодорхойлж болно хэмээн бид үзэж байна. Түүнчлэн, эдгээр үгсийг монгол хүн юуг таашаах, юуг эс таашаах гэх мэт үнэлэмжийг асуудлыг ч нарийвчлан тодруулахад нэгэн хөшүүрэг болгох боломжтой мэт санагдана.

Манай дарга, ажилтнууддаа ширүүн гэж яана. Ёстой хуйхлаад өгнө дөө¹⁸. гэх уран зохиолын жишээнд байгаа “хуйхлах” гэдэг үгийг “уурлаад” гэж соливол

¹⁶Галбаатар Д. (2002) Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар.

¹⁷1564-1616 онд амьдарч байсан зохиолч, жүжигчин. Жүжиг, театрын үүсэл хөгжилд маш их нөлөө үзүүлсэн хүн.

¹⁸Барамсай Ж. (1983) Эмд ордог өвс. 182 х., Улаанбаатар.,

найруулгын эрчим алдагдаж хүч нь сулрах юм. Энэ ньшууд бус нэрлэлт болж буй эдгээр үгс нь өөртөө яруу илэрхийлэх өнгө аясыг агуулж байдаг гэдгийг харуулна. Яруу илэрхийлэх өнгө аяс гэх ойлголт нь өөртөө найруулгазүйн, сэтгэл хөдлөлийн, үнэлэмжийн, уран дүрслэлийн арга замуудыг шингээсэн байна.

Эцэст нь тэмдэглэхэд, шууд бус нэрлэлт бүхий нэгж нь тухайн хэлээр хэлэлцэгч улс үндэстний ахуй амьдрал, хэл соёлын онцлог, зан заншил, угсаатны зүй, утга соёлын уламжлал, сэтгэхүйн өвөрмөц чанар, үнэлэмж, баймж гэх мэт олон асуудалтай холбоотой байдаг байна.

SUMMARY

In the article, we aimed to define how the human character reflected in the verbs which changed to indirect nomination created from suffix.

Conformation and new nominations form novel meaning during word creation fact, which is necessary to present novel meaning as new and it is reported that language marked "First" expression make "second" one. Generally unconformities word is background to describe the meaning of conformation word.

Observation to the meaning of sample verbs could be classified as expression of human character and behavior.

Morpheme, word, sentence and paragraph of indirect nomination are connection with many issues from particular language spoken nation's living conditions, feature of language and culture, custom, ethnography and distinct intellection.